

АЛАШАГИЙН ӨӨРТӨӨ ЗАСАХ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ

*Д.Зоригт**

Япончууд бууж өгсний дараа Дэ ван өөрийн засгийн газрын гол хүмүүсийг дагуулан Бээжинд очоод тэндээсээ Чунцин орж Зян Зиэшитэй уулзан өөртөө засах асуудлыг дахин хөндөн тавьсан боловч Гоминьданы засгийн газар улс орны байдал хүнд байгаа үед энэ асуудал цагаа олоогүй гэдгээр шалтаг хийн хүлээн аваагүй бөгөөд тэдний гол удирдах хүмүүсийг Өвөр Монголд томилон явуулаад түүнийг Бээжинд суулгаж улс төрийн үйл ажиллагааг нь хязгаарласан байна. Ингээд тэрээр 1949 оны 1 дүгээр сар хүртэл Бээжинд гурван жил гаруй суухдаа монголчуудтайгаа байнга харилцахын зэрэгцээ америкчуудтай холбоо тогтоож тэдний дэмжлэгээр Монгол улс байгуулах үйл хэргээ үргэлжлүүлэхээр ажиллаж байлаа. Энд Дэ вангийн улс төрийн үйл ажиллагааны сүүлийн үе шат буюу баруун Монголд өөртөө засах хөдөлгөөн өрнүүлсэн талаар товч өгүүлэх болно.

Хятадын Ардын чөлөөлөх армийн ангиуд 1948 оны сүүлээр Бээжин хотыг бүслээд байдал нэлээд түгшүүртэй болсонд Дэ ван Наньжинд байсан УХэлинд Гоминьданы төв хороотой яаралтай зөвлөж, онгоц гаргуулан намайг аваарай гэж цахилгаан явуулав. Хамтран ажиллаж байсан хүмүүс нь явах хэрэггүй юм биш үү хэмээн ятгахад тэр “Би заавал явж үндэстнийхээ үйлсийн төлөө зүгэнэ. Сталин ирж миний аюулгүй байдлыг баталсан ч би сонсохгүй, заавал явна. Би ерөөсөө үндэстнийхээ үйлсэд зүгэхийг өөрийнхөө үүрэг болгож, хувийн амь нас, эд хогшлыг бодохгүй” гэсэн байна. (З, 674) Бээжин хот “найрамдлаар чөлөөлөгдсөн”-өө тунхагласан өдөр буюу 1949 оны 1-р сарын 1-нд Гоминьданы төв хорооноос онгоц ирүүлж Дэ ванг авсан байна. Тэрээр Монгол-Түвэдийн хорооны Бээжин дэх хэрэг эрхлэх газрын дарга Хэ Жоуминь, Таянчи лам, хиа Түмэндэлгэр нарын хамт тусгай онгоцоор Наньжинд очжээ. Тэднийг онгоцны буудалд УХэлин, Дилав хутагт нар тосч авсан бөгөөд Зян Зиэши түүнийг хүлээн авч уулзан хамт хоол идэв.

Дэ ван Наньжинд очоод удалгүй Америкийн элчин сайдын яамны нэгдүгээр нарийн бичгийн дарга Шултаистай Монголын тухай асуудлаар ярилцав. Хэдэн хоногийн дараа элчин сайд Стюардтай уулзаж, Монголын тусгаар улс байгуулах тухай асуудлаа ярьж, америкчуудаас дэмжлэг хүсчээ. Стюард түүнийг дэмжиж байгаагаа хэлж, саналыг нь засгийн газартаа танилцуулахаар амалсан байна. Дэ ванг Наньжинд байх үед

* Д.Зоригт - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Дилав хутагт түүнд Энэтхэгт очих бодолтойгоо хэлж байжээ. Гэтэл нэг өдөр гэнэт ирж уулзаад Америк явах болсноо дуулгасан байна. Дэ ван түүнийг америкчуудтай байнга харилцах гол хүнээ болгохоор шийдэж, өөрийн хувь хүний төлөөлөгч мөн гэсэн итгэмжлэх бичиг үйлдэн гарын үсгээ зурж, тамгаа дарав. Уг бичгээ Дилав хутагтад өгч та намайг төлөөлөн Америкчуудтай өргөн харилцаа тогтоож, Монголын тусгаар улс байгуулах үйл хэрэгт тэднийг уриалж өгөөрэй гэсэн байна. Үүний зэрэгцээгээр Дэ ван “Монгол залуучуудын холбоо”-ны гол удирдагчид болох Ши Жэньдуй, Захчид Сэцэн, Дагва-Осор зэрэг хүмүүсээр дамжуулан Америкийн тагнуулын байгууллагатай хамтын ажиллагаагаа улам идэвхжүүлэв. Түүнийг Бээжингээс явахын өмнө Дагва-Осор, У Гутин нар ирж “Америкийн мэдээллийн газар биднээс баруун хэсгийн чуулган хошуудад улс төрийн шинэ нөхцөл байдал буй болгохыг хүсч байна. Тэд бүх талаар дэмжлэг үзүүлнэ гэнэ” гэж ярьсан байжээ. (7, 330)

Зян Зиэши дайнд ялагдал хүлээж арга буюу ажлаасаа чөлөөлөгдөхөө мэдэгдэн, Наньжингаас Жэзэнд очсон учир дэд ерөнхийлөгч Ли Зунжэнь ажлыг нь хариуцан үлджээ. Сунь Рэ Засаг захиргааны хорооны дарга болж, Бай Юньти (Цэрэндонров) Монгол-Түвэдийн хорооны даргаар томилогдоод байв. Дэ ван Гоминьданы шинээр томилогдсон дарга нартай нэлээд идэвхтэй уулзан, холбоо тогтоохыг хичээжээ. Тэрээр Ли Зунжэнь-тэй уулзахдаа “Зүүн Монгол эв хамт намын өдөөлгөөр Өвөр Монголын өөртөө засах засгийн ордныг байгууллаа. Одоо үлдсэн баруун чуулганы бүх хошуудад л түргэн нэг холбоот байгууллага байгуулж, эв хамт намын дарлалд дургүйцэж баруун тийш эргэсэн Монголын ван гүн, цэрэг ард болон залуучуудыг зангидаж, хамтаар эв хамт намыг эсэргүүцвэл зохино” гэжээ. Дэд ерөнхийлөгч Ли Зунжэнь үүнийг нь зөвшөөрч байгаагаа хэлсэн байна. У Хэлин Дэ ванг Монголын бүх чуулганы өөртөө засах асуудлыг хянан удирдах даргын албан тушаалд томилж, түүний удирдлагад захиргааны байгууллага буй болгох саналыг тавьж түүнийг нь Монгол-Түвэдийн хорооны дарга Бай Юньти дэмжин төсөл боловсруулаад байжээ. Гэтэл Дэ ван цагийн байдал түргэн өөрчлөгдөж байгаа энэ үед Гоминьданы томилсон даргын албан тушаалд очвол үндэстнийхээ төлөө зүтгэж байгаа монгол залуусын итгэл хүрээллийг алдана гэж үзээд энэ саналыг нь хүлээж аваагүй байна. Дэ ван Гоминьданы Хууль тогтоох хорооны гишүүн Лю Зытунээс ЗХУ-ын элчин сайдад Монголын тусгаар улс байгуулах асуудлын тухай ярьж өгөхийг хүсчээ. Лю дараа нь түүнтэй дахин уулзаж, одоогийн нөхцөлд Дэ ван Монголын тусгаар улс

байгуулахыг бодож байгаа нь маш зохисгүй гэж элчин сайд хэлж байна гэсэн байна. (8, 335)

Хятадын Ардын чөлөөлөх армийн ангиуд ойртон ирж, Наньжинд байдал улам түгшүүртэй болоход Гоминьданы засгийн газрын байгууллагууд хотоос гарч эхлэв. Монгол-Түвэдийн хорооньхон Дэ ванг Хөх нуурын Гүмбум (Гүмбэн) сүмд хүргэж суулгах гэсэн боловч тэр Өвөр Монголын баруун хэсгийн чуулган хошуудад очиж, Монголын өөртөө засах хөдөлгөөнөө явуулахаар бодож байв. Тэр Хөх нуурт очихгүй, харин Алаша руу явна гэсэн саналаа Монгол-Түвэдийн хороонд тавьсан бөгөөд Гоминьданы засгийн газар ч үүнийг нь зөвшөөрсөн байна. Ингээд 1949 оны 1 дүгээр сарын 25-нд Дэ ван нар тусгай онгоцоор Наньжингаас нисч, Ланьжоугаар дамжин Алаша хошууны төв Баян хотод очив. Тэднийг Ланьжоуд ирэхэд Алаша хошууны засагчин ван Дарьзаяа (Руй Сун) утган авч хүндэтгэл үзүүлэв. Дэ ван тэнд хоёр сар гаруй байхдаа тэндэхийн Гоминьданы байгууллагуудын удирдах хүмүүстэй уулзан Монголын өөртөө засах ажлаа дэмжүүлэхээр ярилцахын хамт Дарьзаяа ван, Монгол-Түвэдийн хорооны зарим гишүүн, монгол хошуудаас ирсэн ван гүн, ноёд түшмэлтэй зөвлөлдөж, судалгаа хийсэн байна. Мөн баруун хойт орны цэрэг засгийн ноёдын хуралдаанд оролцохоор ирсэн хүмүүстэй уулзаж, үйл ажиллагаагаа дэмжүүлэхээр тохиролцов. Ингээд бүх чуулган хошуудын төлөөлөгчдийн хурлыг Алаша хошууны төвд хуралдуулах бэлтгэл ажлаа хийхээр тохиролцжээ. Дараа нь Дэ ван Гоминьданы шинэ гуравдугаар дивизийн даргатай холбоо барьж Иньчуанд очоод тэнд түр ирээд байсан Суйюань мужийн нөлөө бүхий хүмүүстэй уулзав. Мөн Их зуугийн чуулганы дарга Алтан-Очир болон бүх хошуудын ван гүн нарт захидал бичиж, тэднийг Алаша хошуунд ирж Монголын өөртөө засах хөдөлгөөнд оролцохыг уриалсан байна.

Тэд 1949 оны 4 дүгээр сарын эхээр Алаша хошууны төв Баян хотод ирсэн бөгөөд Дэ ван Тайвань, Сянган, Гуанжоу зэрэг газруудад зугтан очоод байсан Ли Шуосинь, Жаргалан, У Хэлин, У Гулин, Захчид Сэцэн зэрэг хүмүүстэй цахилгаан илгээж, тэднийг чуулган хошуудын төлөөлөгчдийн хуралд ирж оролцохыг урив. Энэ үед Хятадын Ардын чөлөөлөх арми баруун тийш давшилт хийж, Суйюань мужийн байдал хүндэрсэн тул Улаанцавын чуулганы дарга Ринчинсанги нарын хүмүүс Баян хотод ирэхэд Дэ ван тэднийг мөн Монголын өөртөө засах ажилдаа оролцуулахаар ятгалаа. Ингээд чуулган хошуудаас ирүүлэхээр төлөвлөсөн төлөөлөгчдийн тоо хагасаас илүүд хүрсэн тул тэд 4-р сарын 8-нд бэлтгэл хурлаа хийж, Монголын өөртөө засах асуудлыг ярилцан саналаа солилцов. Төлөөлөгчид өөртөө засах орны хэмжээ, зохион

байгуулалт, нэр зэрэг асуудлыг ярилцсан бөгөөд Дэ ван нарын хүмүүс Монголын нэгдсэн дээд хэмжээний өөртөө засахыг хэрэгжүүлэхийг зорьж байлаа. Дарьзаяа, Бай Хайфэн зэрэг бүлэг хүмүүс нь улс орны байдал хүнд байгаа үед өөртөө засахыг хэрэгжүүлэхдээ дээд доод гэсэн үгийг нэмэх нь зохисгүй юм гээд Өвөр Монголын зүүн хэсэгт нэгэнт Вангийн сүмийн Өөртөө засах холбоот хурал байгуулагдсан тул түүнийг яаран эсэргүүцэхээс зайлсхийвэл зохино гэсэн байр суурьтай байжээ. Тиймээс тэд зөвхөн чөлөөлөгдөөгүй газар орноор хязгаарлаж, зүүн хэсгийн монгол хошуудыг багтаах хэрэггүй гэж үзэж байсны дээр Вангийн сүмийн Өөртөө засахыг ойшоохгүй байх нь ирээдүйд ашиггүй хэмээн тооцож байв. (9,16) Ингээд нэг хэсэг маргалдсаны эцэст олонхи нь Дэ вангийн саналыг зөвшөөрөөгүй тул “дээд хэмжээ” гэдгийг хасахаар болов. Гэвч тэрээр өөрийн дэвшүүлсэн Монголын нэгдсэн өөртөө засахыг хэрэгжүүлэх саналаа хатуу баримтлан Баруун Монголын өөртөө засах засгийн газар гэсэн нэрийг зөвшөөрөхгүй байлаа. Дэ ван...”Монгол бол нэгдмэл юм. Зүүн баруун хоёр хэсэг болон хуваагдвал монголчуудын сэтгэлийг алдах тул Монголын өөртөө засах засгийн газар гэсэн нэрийг баримтлана” гэсэн байна. Санал зөрөлдөн маргалдаж байх энэ үеэр Захчид Сэцэн, Жаргалан, У Гутин, У Шисянь нар Тайвань, Сянган зэрэг газруудаас хүрэлцэн ирж, тэд Дэ вангийн саналыг дэмжсэнээр “Монголын өөртөө засах засгийн газар” гэсэн нэрийг сонгохоор шийдвэрлэсэн байна. Өөртөө засах орны хүрээ хэмжээний асуудал дээр Дэ ван бүх Өвөр Монголыг багтаана гэхэд нөгөөдүүл нь өнөөгийн нөхцөлд ингэж болохгүй гэж зөрөв. Дэ ван одоогоор зүүн хэсгийн чуулган хошуудын газар нутгийг хамаарах аргагүй гэдгийг зөвшөөрсөн боловч Хөх нуур, Синьзяны монгол үндэстний чуулган хошуудыг оруулахаар зүтгэжээ. Хэдэн өдөр маргалдсаны эцэст 1949 оны 4-р сарын 13-нд Алаша хошууны Баян хотод Өвөр Монголын бүх чуулган хошуудын төлөөлөгчдийн хуралдааныг хуралдуулав. Хуралд Их зуугийн чуулганаас 10, Улаанцаваас 5, Шилийн голоос 5, Цахараас 4, Суйюань мужийн Монголын засгийн явдлын зөвлөлөөс 1, Зостын чуулганаас 4, Зуу удын чуулганаас 9, Жирэмээс 4, Хөлөн буйраас 2, Алаша хошуунаас 3, Эзнээ хошуунаас 2, Тайвань, Сянганаас 3, нийт 50 гаруй төлөөлөгч оролцжээ. Хурлын дарга болон долоон тэргүүлэгч гишүүнийг сонгосон ба хуралд Нинся мужийн тэргүүлэгчийн болон Гоминьданы Батлан хамгаалах яамны төлөөлөгчид үг хэлж, баяр хүргэсэн байна. Хурал 3 өдөр хуралдаж Өвөр Монголын өөртөө засах төсөл, Өвөр Монголын өөртөө засах бэлтгэл комиссыг зохион байгуулах, бэлтгэл комиссын зардлыг базаах төсөл, Өвөр Монголын өөртөө засах цэрэг

байгуулах, Өөртөө засах бэлтгэл комиссын жинхэнэ, дэд эрхлэгч, байнгын гишүүнийг сонгох, нийслэл хотод очиж санал дэвшүүлэх төлөөлөгчдийг сонгох зэрэг зургаан төслийг хэлэлцэв. Хурлаас баталсан өргөдлийн бичигт “Өвөр Монголын өөртөө засахаар монгол хошуудыг амаржуулж, улсын батлан хамгаалалтыг бэхжүүлэх явдлын тухай өргөдөл дэвшүүлэх нь: Манай улсын нутаг дэвсгэр өргөн удам, цөөн тоот үндэстэн хязгаар орноор тархан сууж байгаа тул улсын батлан хамгаалалтыг аюулгүй байлгахад зөвхөн цэргийн бэлтгэлийг атгаад зогсохгүй, цөөн тоот үндэстний дотогш хандах хүчнийг нэмэгдүүлэн, чин сэтгэлээсээ бүлгэмдэж, улс гэр үндэстнийхээ төлөө хамтаар тэмцэж тусалцвал зохино... Манай Өвөр Монголын ард түмэн хоёр зуун түм байх бөгөөд утга соёл, аж ахуйн хэр хэмжээ бас өдөр ирэхүйеэ давшилттай болж ирсэн болохоор улсын нэг хэсэг хариуцлагыг хуваан үүрэглэж болох бөгөөд нэн ялангуяа өөрийн биеэ засах аливаа үүргийг лавтай хариуцаж чадах юм. Иймээс арав гаруй жилийн турш манай Өвөр Монголын хүмүүс нааш цааш гүйж, хүсэлт гарган Өвөр Монголыг өөртөө засахаар шаардсан бол уул нь энэхүү бодит байдалд суурилсан юм. Нэн ч ерөнхийлөгчийн гурван ардчилсан үзлийн гэрээс сургаал хийгээд дэлхийн үндэстний чөлөөлөлтийн хандлагын шаардлагаас эшилсэн юм. Эдүгээ улсын батлан хамгаалалт болон улсын дотоодын ерөнхий байдлын хандлагаас үзэхэд манай Өвөр Монгол эрхбиш бүлгэмдэн нэгдэж, өөрийгөө аврах, улсаа аврах ёсыг шинжлэн эрх л болжээ. Төлөөлөгчид энэ их хурлын шийдвэрийн ёсоор нэгэнт Өвөр Монголын өөртөө засах бэлтгэл комиссыг байгуулаад, өөртөө засах аливаа ажил үйлсийг базааж эхлэв. ...Хүндэт та бүхэн Монголын ард түмний улсдаа зүтгэх цэгц үнэн сэтгэл ба өөрийгөө аврах бачим сэтгэлэгээр гуйчлал гаргасныг санагалзаж, бүх талаас авч үзэн, эзний эрхээр эрс тасархай, үтэр түргэн зөвшөөрөл соёрхож, Өвөр Монголын өөртөө засахыг нийтэлвээс улсын бодлогод нийцэх мөртөө хил хязгаарыг бататгаж чадна...” гэх зэргийг дурджээ. (4, 696-697) “Өвөр Монголын өөртөө засах бэлтгэл комиссын зохион байгуулалтын ерөнхий хөтөлбөр” нь түүний үүрэг зорилт, бүтэц, зохион байгуулалт, эрх хэмжээ, үйл ажиллагааны чиглэл зэргийг тодорхойлж өгсөн бөгөөд дотроо нарийн бичгийн, ерөнхий явдлын, зөвлөхийн, эдийн засгийн, ардыг хамаарах, сурган хүмүүжлийн, эрүүлийг хамгаалах, аюулаас хамгаалах, бүтээн байгуулалтын зэрэг газруудтай байхаар заасан 19 зүйлтэй юм.

Хуралдаан дуусмагц Дэ ван Гоминьданы төв хороонд өргөдлөө мэдүүлэхээр мордсон бөгөөд бусад бэлтгэл ажлаа ч гардан хийв. Тэд

Өвөр Монголын Ардын төлөөлөгчдийн их хуралд бүх чуулган хошуудаас оролцох төлөөлөгчдийн тоог тогтоож, Монголын өөртөө засах засгийн газрын зохион байгуулалтын хууль, Монголын өөртөө засах засгийн газрын тунхагийг боловсруулсан байна. Бэлтгэл комисс байгуулагдаад Гоминьданы Засаг захиргааны хороо болон Монгол-Түвэдийн хороонд цахилгаан явуулж, Өвөр Монголын өөртөө засахыг хэрэгжүүлэхээр шаарджээ. Мөн Дэ ван тэргүүтэй долоон хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид 5 дугаар сарын дундуур Алашагаас гарч, Ланьжоугаар дайран онгоцоор Гуанжоу руу явлаа. Төлөөлөгчид 5-р сарын 18-нд Гуанжоуд очиж, ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч Ли Зунжэнь, Монгол-Түвэдийн хорооны дарга Бай Юньти нарт бараалхан ирсэн зорилгоо танилцуулав. Ли Зунжэнь ямар ч хариулт өгөлгүй Засаг захиргааны хорооны дарга болон Дотоод явдлын яамны удирдлагуудтай уулзаж зөвлөөрэй гэсэн байна. Гэтэл Засаг захиргааны хорооны дарга Хэ Инцинь ажилтай гэж шалтаглаад уулзсангүй. Ингээд Дотоод явдлын яамны сайд Ли Ханьхун-тай уулзан учир байдлаа танилцуулсанд тэр энэ асуудлыг Засаг захиргааны хорооны хуралд танилцуулж шийдвэрлүүлэх арга бодох хэрэгтэй гэлээ. Яг энэ үед Гоминьданы Засаг захиргааны хороонд өөрчлөлт хийж, даргаар нь Янь Сишань томилогдсон бөгөөд Монгол-Түвэдийн хорооны даргаар Гуань Зиюй-г томилжээ. Дэ ван шинээр томилогдсон Засаг захиргааны хорооны дарга Янь Сишань-тай уулзахад ийм үед өөртөө засахыг хэрэгжүүлэх нь төвд хүндрэл учруулахаас гадна улсад ч монголчуудад ч ашиггүй явдал шүү гэж анхааруулав. Дэ ван түүнд учир байдлаа нэлээд тайлбарлаад эцэст нь “одоогийн нөхцөл байдалд төвөөс эс зөвшөөрсөн ч монголчууд өөртөө засахыг явуулна” гэж тулгасан байна. Янь Сишань энэ үгэнд нь их дургүйцэж, үүнийг чинь яасан ч зөвшөөрөхгүй гээд зарлигийг сонсохгүй бол төвөөс цэрэг дайны арга хэрэглэнэ гэжээ. (7, 340) Дэ ван түүнд туйлын дургүйцсэн боловч асуудлаа Гоминьданы төв хороогоор зөвшөөрүүлэхийн тулд хүлцэн тэсвэрлэж, Янь Сишанийг аргадаж байлаа.

Ингээд Дэ ван Америкийн элчин сайдын яаманд очиж, Шультаис-тай уулзан түүнд бүх явдлыг танилцуулсанд тэр “түрүүчийн тавьсан саналыг чинь манай улсын засгийн газар авч үзээд чамайг Монголын төлөөлөгч хэмээн зөвшөөрч байгаа бөгөөд үүнээс хойш Монголын холбогдолтой хэргээр чамтай харилцана гэж мэдэгдсэн. Одоо та нар нэгэнт өөртөө засах асуудлаа хөөцөлдөж байгаа тул бид танай тэнд төлөөлөгч томилон суулгахаар бэлтгэж байгаа...” гэсэн байна. (5, 342) Дэ ван 4-р сарын эхээр Наньжингаас Ланьжоуд ирж, Америкийн агаарын тээврийн нэгэн компаний ажилтантай

уулзахад АНУ-ын дэмжлэгийг хүсч байвал Бүгд найрамдах намын гол хүн Алумэнтэй харилцаж өгье гэжээ. Тэр АНУ-аас буу зэвсэг, зардал мөнгө, нисэх онгоц зэргээр туслахыг хүсч байгаагаа илэрхийлэв. Тэр үед Дэ вангийн шадар туслах Дагва-Осор мөн Ланьжоуд байсан Америкийн нэгэн байгууллагатай харилцаж ачааны машин авчээ. Америкийн тагнуулын байгууллагын ажилтан Сарихи будахдаа Дэ ванд цахилгаан холбооны хэрэгсэл өгч, өөртэйгөө харилцаж байх боломж бүрдүүлж өгөв. Гуанжоуд байхдаа Дэ ван мөн Захчид Сэцэн, Жаргалан нартай хамт хотын захад Америкийн тусгай албаны ажилтан Майштай нууцаар уулзаж, түүнд баруун Монголын өөртөө засахтай холбоотой асуудлуудаа танилцуулан тусламж үзүүлэхийг хүссэнд тэр үйл ажиллагааг нь сайшааж, дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн байна. Майш цахилгаан холбооны хэд хэдэн хэрэгсэл өгсний дотор бензинээр ажилладаг хөдөлгүүр бүхий алсын холбооны аппарат нэг байжээ. Тэрээр зориуд сургаж бэлтгэсэн Синьзянь болон зүүн Монголын найман тагнуулчинг мөн томилон үлдээсэн байна. Эдгээр хүмүүс холбооны хэрэгслээ авч Алаша хошууны баруун хойгуур Өвөр Монгол болон манай улсын хилийн заагт байх Баянзандан орчмоор нууцаар таран байрласан байна. Дэ ван тэднийг Дагва-Осорг хариуцуулж, Өвөр Монгол болон манай улсын байдлыг тагнан мэдээлэл цуглуулж, Америкийн талд цаг тухайд нь дамжуулж байлаа. Үүний дараа Америкийн тагнуулын байгууллагын төлөөний хүн Фрэнк Бэсак нэгэн америк хүний хамт Алаша хошуунд нууцаар ирж, элчин сайдын яамны нэрийн өмнөөс Дэ вантай харилцаж эхэлснээс гадна хожим нь хуралдуулсан Монголын ардын төлөөлөгчдийн хуралд оролцсон байна. (6, 549)

Дэ ван Гуанжоугаас буцахдаа төлөөлөгчдийн нэрийн өмнөөс Монгол-Түвэдийн хорооны дарга Гуань Зиюй-д хоёр зүйлийн шаардлага тавьсан бөгөөд үүндээ “Өвөр Монголын найман чуулган, харьяат дал гаруй хошууны олонхи нь эзлэгдсэн газар орон болж, үлдсэн бүх чуулган хошууд ч мөн сүрдүүлийн дор байж, аюул тулгарах нь өглөө үдшийн хэрэг болов. Иймийн тул тус төлөөлөгчдийг сонгон гаргаж, энд ирүүлсэн нь Өвөр Монголын өөртөө засах засгийн газрыг байгуулахыг гуйчлахаас гадна Монголын өөртөө засах цэргийг зохион байгуулах, жич цэргийн тал ба аж ахуйн талын тусламжийг гуйчлуулж, монголчуудыг уриалан санал нэгтэй эв хамт намыг эсэргүүцэж мөхлөөс аврахын төлөө аливаа байдлыг дахин давтан тодорхойлон тоочсон боловч төвөөс төлөөлөгчдийг буцахыг шаардав. Ингэж буцахад хүрвэл Монголын цэрэг ардын сэтгэл зайлшгүй цөхрөх болно” гэж дурджээ. Үүндээ мөн “Монголын чуулган хошуудын хамтран сэргийлэх комиссыг зохион

байгуулж, төвийн ба газар орны цэргийн талын дарга ноёдын жолоодлого дор бүх чуулган хошуудын үлдэгдэл амрыг хамгаалах цэрэг ангийг цэгцлэхийн хамт дайсанд эзлэгдсэн бүх чуулган хошуудын эв хамт намыг эсэргүүцэх цэргийг хураамжлан цэгцэлж аваад хамтаар дээрмийн аюулыг сэргийлнэ. Хамтран сэргийлэх комиссын цэрэг ангиа цэгцлэн тохиуулахад хэрэглэх зардалд төвөөс түмэн хүний хэрэглэх зэр зэвсэг, сум дарь, хувцас хунар, хоол хүнс хийгээд дайнд чухал хэрэгцээтэй аливаа хангалтыг өгөх болову...” гэсэн агуулгатай зүйлийг багтаажээ. Энэ шаардлагыг Засаг захиргааны хороонд танилцуулахад Янь Шишань зөвшөөрсөн цохолт хийсэн байв. (5, 344) Ингээд Засаг захиргааны хорооны дэд дарга нь Дэ ван нартай уулзаж, Эдийн засгийн болон Батлан хамгаалах яамдал мэдэгдэж зардал, зэр зэвсэг гаргуулж өгье, та нар эртхэн хариарай гэсэн байна. Гоминьданы засаг захиргаа өөртөө засах асуудлыг эрс эсэргүүцэж байснаа яагаад ийнхүү эргэх болов гэвэл тэдний ноёрхол дуусахад ойрхон болсныг мэдээд Дэ ванг ашиглан умард хязгаарт коммунистуудыг эсэргүүцэх ажиллагаа явуулахыг сэдсэнээс гадна америкчуудын дэмжлэг байгааг мэдэх учир зөвшөөрсөн эс зөвшөөрсөн ч Монголын өөртөө засах хөдөлгөөнөө явуулна гэдгийг ойлгож байсан ажээ. Ингээд Дэ ван Эдийн засгийн болон Батлан хамгаалах яамнаас тус бүр арван мянган юанийн мөнгөн зоос, дөчин мянган сумтай хоёр зуун винтов, 2500 сум бүхий тавин канад гар буу авч, Тайваниас буцаж ирсэн Ли Шоусинь, Гоминьданы хууль тогтоох гишүүн бөгөөд хянан шалгах гишүүн Түмэндэлгэр, Тогтох, Насанбөх, Гуанжоуд байсан хэсэг монгол оюутан залуучуудын хамт хорин есүүлээ 7-р сарын 10-нд тусгай онгоцоор Нинсягаар дамжин Алаша хошуунд иржээ. Дэ ван Монгол-Түвэдийн хороонд цахилгаан илгээж, Өвөр Монголын өөртөө засах бэлтгэл комиссын зардалд сар бүр гучин мянган юань олгохыг шаардахын хамт Гуанжоуд байгаа У Хэлин, Зуунаст нарт “Монголын чуулган хошуудын хамтран сэргийлэх комисс” байгуулах төслийг Засаг захиргааны хороо, Монгол-Түвэдийн хороогоор зөвшөөрүүлэх ажлыг яаралтай хийхийг даалгав. Дээрх газрууд уг төслийг нь хэлэлцээд комисс байгуулахыг зөвшөөрсөн байна. Ли Шоусинь энэ шийдвэрийг үндэслэн урьд нь захирч байсан гурван мянган хүнтэй морьт цэргийн нэгдүгээр бригадаа Суйюань мужаас авахаар хөөцөлдөв. Ингээд “Шаньси, Ганьсу, Нинсягийн хязгаарын морьт цэргийн ерөнхий жанжин штаб”-ыг байгуулахаар тохирч, Ли Шоусинь-ийг даргаар нь томилсон байна. Сүхбаатарын захирч байсан монгол морьт цэргийн нэгдүгээр бригадыг нэгдүгээр дивиз болгож өөрчлөн байгуулав. Дараа нь гурван дивиз болгон өргөтгөж,

морьт цэргийн арми байгуулахаар төлөвлөж байв. Цэргийн бүх зардлыг Нинся мужийн засгийн газраас түр гаргахаар болжээ.

Зуун дал гаруй төлөөлөгч оролцсон Монголын их хурал 8-р сарын 5-нд эхлэв. Өмнө нь бэлтгэл хуралдаан хийж, Дэ ван, Дарьзаяа, Бай Хайфэн, Ринчинсанги, Ли Шоусинь, У Жаолин, Ба Вэньзюань, Бай Руй, У Хэлин нарын 9 хүнийг хурлын тэргүүлэгчээр сонгожээ. Дэ ван нээлтийн үг хэлж, монгол үндэстэн түүхэнд яаж хүчирхэгжин мандсан тухай ярьж, Юань улсын тулгуур төрийн гэрэл цацрангүй зуугаад жилийн түүх болон ёсоор засч, хүчээр захираад олсон амжилт бүтээлийг тоочив. Одоо монгол үндэстэн ядуу хоосон, дорой буурай байгааг дурдаж, эрч зоригоо гүйцэд бадруулан, өнгөрсний адил нэр сүрээ сэргээн мандуулж, ирээдүйн их үйлсийг бүтээсүгэй хэмээн уриалжээ. Одоогийн энэхүү өөртөө засах хөдөлгөөн бол тэнгэрийн санаа, хүний сэтгэлд нийцэх ажиллагаа мөн гэж тодорхойлоод эцэст нь Чингис хааны аймаг олноо нэгтгэн нягтруулахын тулд хэлсэн үгийг дурдан, монголчууд бүлгэмдэн нэгдэж, хамтаар тэмцэн өөртөө засах хөдөлгөөний ялалтыг олсугай гэсэн байна. Тэрээр хурал дээр их Юань улсын ёсоор засч, хүчээр захирах арга бодлогыг магтан сайшаахын зэрэгцээ хуралд оролцсон монголчуудыг үндэстнээ сэргээн мандуулах үйлсийн төлөө идэвхийлэн зүтгэж, хувь нэмрээ оруулахыг уриалав. Эцэст нь “хэрэв эв хамт нам ирэх юм бол үндэстэн ч байхгүй, өөртөө засах явдал ч үгүй болох юм...” гэжээ.

Дараа нь У Хэлин, Захчид Сэцэн, Номбаатар, Саграажав, Дамиранванчиг зэрэг арав гаруй хүн үг хэлж, Монголын өөртөө засахын чухлыг онцгойлон дурдсан байна. Хурлаар Монголын өөртөө засах засгийн газрын зохион байгуулалтын хууль, Өөртөө засах засгийн газрын бүх тэнхим, захиргаа, эвлэлийн зохион байгуулалтын хууль болон Монголын өөртөө засах тунхаг зэрэг бичиг баримтын төслийг хэлэлцэв. Хуралд Америкийн тагнуулын ажилтан Фрэнк Бесак нэг америк хүний хамт оролцсон бөгөөд Английн нэг сурвалжлагч байв. (5, 356-357) Их хурлаас Дэ ванг Монголын өөртөө засах засгийн газрын тэргүүлэгч, Дарьзаяаг дэд тэргүүлэгч, У Хэлин-г Зөвлөлгөөний хурлын дарга, Насанбатыг дэд даргаар сонгож, 8-р сарын 10-нд Монголын өөртөө засах засгийн газар байгуулагдсаныг мэдэгдэн тунхаг гаргав. Есөн хүнийг засгийн газрын гишүүнээр томилж, нарийн бичгийн тэнхим, дотоод явдал, эдийн засаг, боловсрол, үйлдвэр худалдааны дөрвөн захиргаа болон аюулаас хамгаалах комисс зэргийг байгуулан дарга нарыг нь томилсон байна.

Монголын ардын төлөөлөгчдийн их хурлын тунхаг “Монголчууд өөртөө газар нутагтай, ард иргэдтэй, улс төрийн зохион байгуулалттай

бөгөөд үндэстний эрс хатуу үзэл ухамсартай улс бөлгөө. Манай өвөг дээдэс дэлхий дахинаа хамгийн хүчирхэг том улсыг байгуулж өнгөрсөн бөгөөд хойчистоо гэрэл сацрангуй түүхээ үлдээж өгсөн юм. Орчмын жилүүдэд дэлхий дээрх аливаа дарлагдаж бүхий үндэстнүүдийн ихэнх нь дарлал мөлжил хийгээд хүлээс тушаагаа авч хаян, эрх чөлөөгөө олж, тусгаар тогтнох, өөртөө засах замд алхан оров. Гэтэл манай монголчууд аз бусаар дотоодын самуун гадаадын аюулд хавчигдан, нутаг дэвсгэр нь харийн дайсны төмөр туурай дор гишгэлүүлж, хүмүүний дураар тамлагдмой... Ялангуяа дэлхийн хоёрдугаар их дайн дууссаны дараа дэлхийн байдал тогтуун биш болоод дотоодын самуурал, гадаадын түрэмгийлэл өдрөөс өдөрт хэцүүдэж байгаа байдал дор монгол үндэстний мөхөх сэхэхийн эцсийн зангилаа цаг болсон тул бид нар даруй түргэн бүлгэмдэн босолцож, үндэстнийхээ оршин тогтнохын төлөө эс тэмцвээс үл болох ажээ...

Сун Жуншань-ий гэрээс сургаалыг үндэслэн, үндэстний өөртөө засахыг хэрэгжүүлж, Монголын өөртөө засах хуулийг баталж, Монголын өөртөө засах засгийн газрыг байгуулав. Монголын бүх чуулган хошууны уулын нутаг дэвсгэрээр манай өөртөө засах хүрээ хэмжээ болгомой... Үүнээс хойшхи Монголын өөртөө засах үндсэн хөтөлбөр болбоос улс төрийн талаар ард түмний үндсэн ашиг тус эрх мэдлийг гүйцэд баталж, үнэнхүү ардчиллыг явуулан, Монголын өөртөө засах нутаг дэвсгэр дор харьяалагдаж бүхий ард түмэн бүрмөсөн эрх тэгш байж, үндэстэн угсаа, шашин суртахуун, чанарын ялгал, анги, итгэл бишрэлийн адил бус гэж ялгалгүй бүр адил тэгш харгалзлалыг хүртээмүй. Аж ахуйн талаар ард түмний эд хогшлыг баталж, ядуу хоосон ах дүү нарынхаа амьдралын хэр хэмжээг дээшлүүлж, үндэстний аж ахуйг зэргээр хөгжүүлэхээр чармаймуй. Соёл гэгээрлийн талаар сурган хүмүүжлийг түгээмэлжүүлэхээр чармайж, дэлхийн шинэ соёлыг оруулж, уулын байсан соёл мэдлэгээ хөгжүүлмүй. Цэргийн явдлын талаар үндэстний өөрийгөө хамгаалах хүчнийг чангатгаж, Монголын ард түмнээ хамгаалан, орон нутгийн эмх дэглэмийг тогтворжуулж, аливаа түрэмгийллийг эсэргүүцмүй...

Бид төвийн засгийн газрын удирдлага дор улсын бүх үндэстэнтэй чин үнэнчээр бүлгэмдэж, Монголтой ойролцоо бүхий л мужтай нягт харилцаж, ардчилсан эрх чөлөөний тэмцлээ хамгаалан биелүүлэхийн төлөө хамтран тэмцмүй... Одоо бүх Монголын ард түмэн эрэлхэгээр гэдийн босч, үндэстнээ оршин тогтноулж, өөртөө эрх мэдэх болгохын төлөө дархан үүргийг үүрэглэж, чармайн урагшилж амой. Бүх улсын ах дүү нарыг хүсэх нь, Монголын өөртөө засах хөдөлгөөн болбоос дотооддоо хандсан өөртөө засах болохоос бус гадагш хандаж хагацах

хөдөлгөөн биш гэснийг ойлгон үнэн ёсны дэмжлэг өгөх боловuu. Бүх дэлхийн үнэн ёсыг баримтлагч хүмүүс сайшаан дэмжиж, хавсарлага үзүүлэхийг хүсмүй...” (3, 734-735)

Монголын өөртөө засах засгийн газар байгуулагдах үеэр баруун хойт нутгийн цагийн байдал нэн түгшүүртэй болж ирэв. Тайваниас ирж Монголын өөртөө засах хөдөлгөөнд оролцох гэж байсан Ши Жэньдуй нар Ланьжоуд ирээд Гоминьданыхан ялагдаж, Хятадын Ардын чөлөөлөх арми баруун хойш чиглэснийг мэдээд тэндээсээ буцсан байна. Дараа нь У Хэлин, Захчид Сэцэн, Жаргалан, У Гутин, У Шисянь, Бай Руй зэрэг хүмүүс мөн хойно хойноосоо цувран явцгаасан байна. Захчид Сэцэн Америкт очихоо хэлсэнд Дэ ван түүнд Монголын өөртөө засах засгийн газрын төлөөлөгч гэсэн гэрч олгож, тэнд очоод хэрхэн ажиллах талаар зааварчилжээ. Дээр дурдсан зарим хүнд ч Гуанжоуд очоод засгийн газраа зөвшөөрүүлэх асуудлыг хөөцөлдөөрэй гэж захисан байна. У Хэлин нар 8 дугаар сарын дундуур Гуанжоуд очиж, Монгол-Түвэдийн хороонд Монголын их хуралд оролцсон байдлаа танилцуулахын хамт Гоминьданы төв хороонд Монголын өөртөө засах засгийн газрыг зөвшөөрүүлэхээр шаардлага тавьжээ. Жаргалан нарын гурван хүн хурлын байдлын тухай дэлгэрэнгүй илтгэл бичиж танилцуулан саналаа дурдсан байлаа.

Энэ үед Ланьжоу чөлөөлөгдөж, Нинсягийн байдал түгшүүртэй болж ирэв. Дэ ван нар Алаша хошуунд буцаж ирэх үед Ардын чөлөөлөх армийн 19 дүгээр хороо Нинсяд орж ирээд байлаа. Тэд зөвлөлдөн ярилцахад Дэ ван Монголын өөртөө засах засгийн газраа Алаша хошуунаас хойш тал газар руу нүүлгэж, дараа нь Энээнэ хошуугаар дамжин Хөх нуурт суурьшуулах, аргагүй байдал тохиолдвол Түвд, Энэтхэгтэй харилцан дэмжлэг авч болно гэж үзэж байгаагаа хэлсэн байна. Тэд Гуанжоуд үлдсэн Зуунастад цахилгаан явуулж, чуулган хошуудыг хамгаалж байгаа цэргийн хангамж, ялангуяа хоол хүнс хомсдож байгааг төвд мэдэгдэн гаргуулах, урьд нь халгалуулсан буу зэвсэг, сум хэрэглэлийг тусгай онгоцоор ирүүлэх хүсэлт тавихыг даалгасан байна. Мөн Монгол-Түвэдийн хороонд явуулсан цахилгаандаа “Эдүгээ бүх чуулган хошууны холбоот цэрэг бараг түм шахам хүн хүч дайсныг эсэргүүцэн Алаша хошууг хамгаалахаар зориг шулуудаж, аргагүй байдалд орвол гэдрэг ухран Алаша хошууны манхнаа сахихаар тогтлоо. Гагцхүү зэр зэвсэг, сум дарь, жич эмээр хомсдож, нэгэнт хүчирдэл тулгарав” гээд яаралтай туслахыг хүссэн байна. Монгол-Түвэдийн хороо цахилгааныг хүлээн аваад Засаг захиргааны хороонд тодорхой санал оруулж, зуун дөчин мянган мөнгөн зоос олгуулахаар хүсэлт тавьжээ. Энэ үед Гоминьданы хувь заяа үндсэндээ тодорхой болоод байсан тул Засаг

захиргааны хороо Монгол хязгаарт коммунистуудыг хориглох үүднээс Монгол-Түвдийн хорооноос дурдсан зардлыг олгуулахыг зөвшөөрөв. Удалгүй Зян Зизшигийн бүлэг Тайваньд зугтан гарсан учир энэ мөнгө хэний гарт орсон нь ч тодорхойгүй болсон байна. (9, 39)

Нөхцөл байдал тэдэнд улам ашиггүй болж ирсэн энэ үед Дэ ван нар Монголын өөртөө засах засгийн газраа Алаша хошууны баруун хойт хэсгийн тал газарт шилжүүлэх гэхэд Дарьзаяа зэрэг хүмүүс эсэргүүцэж, үүнээсээ болж хоёр бүлэг салсан байна. Дэ ван нар тэнд суугаад байх нь ашиггүй гэж үзээд шөнийн цагаар Баян хотоос сэмхэн гарч, товлосон газар руугаа явсан бөгөөд урьд нь нууцаар Баянзанданд томилон явуулсан тагнуулчдаараа дамжуулан Америкчуудтай харилцаж, тэдний дэмжлэгээр олон улсын тусламжийг авахаар төлөвлөсөн байна.

Энэ үед Түвшин Дэ ванг дахин ятаж, хөнгөн хөдөлж болохгүйг сануулан дахиад баруун тийш явах гэвэл Япон бууж өгөх үед Чуулалт хаалгаас зугтаж шившгээ үзүүлсэн шиг юм болно гэхэд тэр “Зэлүүд газар очиж, эв хамт нам монголчуудын талаар ямар бодлого явуулахыг ажиглая. Бид огт явах замгүй болчихоогүй байна. Хөх нуур, Түвдээр дамжин Энэтхэгт очиж, тэндээсээ гадаадад гараад бүх улсаар тойрон явж, Монголын асуудлыг ухуулан дэлхийн байдал хувирахыг хүлээж болно. Мөн Ар Монголтой харилцаж болно. Урьд нь би тэдэнтэй холбоотой байсан. Одоо ч Алтан-Очир нарыг томилон харилцаж байна. Миний үзэхээр тэд бидэнтэй адил монгол хүмүүс тул түгшүүрт тулгараад тусламж гуйхад угсаа нэгтний хувьд биднийг үлдээн авах буюу тусламж үзүүлэх байх” гэжээ. (8,374) Түвшин баруун тийш нэвтрэх боломжгүй болсон, Ар Монголд очвол буцаан хүргэгдэх болно гэдгийг тайлбарласан боловч Дэ ван урьд нь япончуудтай хамтран ажилласан, одоо ч Гоминьдантай харилцаж байгаа тул коммунистууд биднийг хэрхэвч уучлахгүй гээд саналыг нь хүлээж аваагүй байна.

Ли Шоусинь Нинся мужид байрлаж байсан цэргээ дагуулан Алаша хошуунд ирж, Төхөмийн сүмд Дэ вантай уулзав. Нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалан тэд Засгийн газар болон Зөвлөлгөөний хуралдаа өөрчлөлт хийж, зарим хүмүүсийг албан тушаалуудад томилов. Мөн Монгол цэргийн ерөнхий жанжин штабыг байгуулж, цэргээ морьт цэргийн хоёр дивиз болгон Чингис хааны он тоолол болон Чингис хааны гурван алаг тугийг хэрэглэжээ. Дэ ван өөрөө Монгол цэргийн ерөнхий жанжин штабын дарга болж, Ли Шоусинь-ийг орлогчоор, Бао Гуйтинг штабын дарга, Дүүрэнсанг орлогчоор нь томилсон байна. Сүхбаатарыг нэгдүгээр дивизийн дарга, Жарантайг хоёрдугаар дивизийн дарга

болгов. Ингээд тэд төлөвлөсөн ёсоороо Алаша хошууны хойгуурх элсэн манхнаар гарч, хэдэн сар явж суусаар 11-р сарын сүүлчээр тус хошууны баруун хойт хязгаарын Горной голын орчимд хүрсэн байна.

Энэ үед Хятадын Ардын чөлөөлөх арми Ганьсу мужийн ихэнх хэсгийг чөлөөлснөөр Дэ ван нарын баруун тийш явж, Хөх нуур, Түвдэд очих гэсэн төлөвлөгөөг тасалсан байна. Байдал улам хүндэрсэнд Дэ ван өөрөө Хар эрэгт очиж, манай улсын Дотоод явдлын яамны төлөөлөгчтэй нууцаар уулзсан байна. Энэ үед ид өвлийн хүйтэн болж, цэрэг нь хоол хүнсээр, агт морьд нь өвсөөр тасарч байдал маш хүнд болжээ. Цэргүүд нь малчин ардуудын мал, эд зүйлсийг дээрэмдэн, элдэв хэрэг үйлдэх болсон тул хавийн айлууд ч дайжин нүүсэн байжээ. Дараа нь тус хошууны амрыг хамгаалах цэрэг болон малчин ардуудын зохион байгуулсан зэвсэгт бүлэг Дэ вангийн цэрэгтэй хэд хэдэн удаа мөргөлдөөн үүсгэж, олон хүнийг алж шархдуулсан явдал гарчээ. Цэргүүд нь малчин ардуудаас гурван мянга гаруй тэмээ булаан авч хүнсэндээ хэрэглэсэн байжээ.

Дэ ванг явсны дараа Дарьзаяа, Бай Хайфэн, Хэ Жаолинь, Ба Вэньзюань зэрэг хүмүүс зөвлөн ярилцаад Монголын өөртөө засах засгийн газар гэдэг нэрээ Баруун Монголын өөртөө засах засгийн газар болгон өөрчилжээ. Тэдний ийнхүү нэрээ өөрчилсөн нь Хятадын ихэнх нутаг дэвсгэр чөлөөлөгдсөн тул хамаарах хүрээ хэмжээгээ багасгахаас гадна Улаан хот дахь Өвөр Монголын өөртөө засах засгийн ордонтой сөргөлдөж үндэстнээ салган тусгаарласан ял хүлээхээс зайлсхийсэнд байжээ. Тэд дахин ярилцаад Хятадын коммунист нам болон Мао Зэдунд цахилгаан илгээж Ниньсяг чөлөөлөхөөс өмнө амжиж найрамдлаар чөлөөлөгдье гэж тохиролцов. Ингээд Дарьзаяа, Бай Хайфэн, Хэ Жаолинь, Ба Вэньзюань нарын дөрвөн хүн Баруун Монголын өөртөө засах засгийн газар эргэлт гаргах цахилгааны эх бичигт гарын үсэг зурж, ХКН, Мао Зедун болон Бүх улсын Улс төрийн зөвлөлгөөнийг дагаж чөлөөлөгдөхөө илэрхийлсэн байна. Тэд Алаша хошууны Амрыг хамгаалах ерөнхий цэргийн дэд дарга Луо Руйгуан-ыг Баруун Монголын өөртөө засах засгийн газрын тэргүүлэгчээр томилон Иньчуань-д илгээж, Нинсяд орж ирсэн Ардын чөлөөлөх армийн ангийнхантай уулзуулжээ.

Арваад хоногийн дараа Ардын чөлөөлөх армийн нэг хороо Алаша хошуунд орж ирэхэд Дарьзаяа нар Баруун Монголын өөртөө засах засгийн газрыг төлөөлөн тэднийг угтав. Дарьзаяа нарын дээр дурдсан дөрвөн хүн 10-р сарын 5-нд Иньчуаньд ирж, ХАЧА-ийн холбогдох хүмүүст байдлыг танилцуулан, Алаша хошуунд ажиллаж байсан Гоминьданы тусгай албаны ажилтнуудыг зэр зэвсэг, холбооны хэрэгслийн нь хамт тэдэнд шилжүүлэн

өгчээ. Дараа нь Бай Хайфэн, Хэ Жаолин нар Ланьжоу, Хөх хот, Бээжинд очиж, Пэн Дэхуай, Улаанхүү болон ерөнхий сайд Жоу Эньлай нартай уулзав. Тэд “Баруун Монголын өөртөө засах засгийн газар”-ын эргэлт хийгээд Дэ ван, Ли Шоусинь нар монгол цэргийг дагуулж явсан тухай болон Алаша хошууны байдлыг танилцуулав. (9, 54)

Сүүлд нь Өвөр Монголын өөртөө засах засгийн ордны тэргүүлэгч Улаанхүү Дэ ван нарт захидал хүргүүлж, тэднийг ард түмний талд буцан ирж, чөлөөлөлтийг хүлээн авахыг хүссэн байна. Мөн Бай Хайфэн, Хэ Жаолин хоёрыг Дэ ван, Ли Шоусинь нарын мэдэлд байгаа цэрэг, засгийн хүмүүсийг коммунистуудын талд татан авах ажлыг хийлгэхээр Алаша руу явуулжээ. Тэднийг ард түмний талд ирвэл урьдын ял гэмийг нь огт тооцохгүй гэж Улаанхүү тэдэнд зааварчилсан байлаа. Үүнээс өмнө ч энэ чиглэлээр нэлээд ажил зохиосон бөгөөд Дарьзаяагаар Дэ ванд захидал бичүүлж ятгуулснаас гадна түүнийг Нинсяд ирж, цэргийн талын асуудлаа ярилцахыг урьсан байна. (9, 56)

Дэ вангийн удирдлагад байсан хүмүүсийн нэг хэсэг нь Нинься-д очиж чөлөөлөлтийг хүлээн авах, зарим нь Ар Монголд очих замыг эрэлхийлэх, нөгөө хэсэг нь баруун тийш явж, Америк болон Зян Зиэшиг түшиглэхийг зорьж байсан бөгөөд тэдний дийлэнх олонхи нь баруун тийш явахыг хүсч байжээ. Дэ ван өөрөө баруун тийш явахыг зорьж байсан боловч коммунистууд Нинься-гаас цэрэг гаргаж тэднийг цохиулахаас эмээж байсан тул энэ завшааныг ашиглан төлөөлөгчөө илгээж хэлэлцээ хийх маягаар бачим байдлыг түр намжаахаар шийдсэн байна. Хэлэлцээний үеэр цэрэг ирүүлэхгүй тул энэ хугацааг ашиглан баруун тийш явж болно гэж тооцов. Ингээд Түвшинг төлөөлөгчөөр томилж, түүгээр хүргүүлэх захидалдаа “Нэгд: Эрхэт ардын сонгуулийн аргаар Ар Өвөр Монголыг нийлүүлэх. Хоёрт: Гоминьданы засгийн газраас монгол хошуудыг хэсэглэн ноёрхож байгаа хязгаар орны мужийн засгийн газрыг устгаж, Монголын өөртөө засах байгууллагын харьяа болгох. Гуравт: Миний толгойлж байгаа Монголын өөртөө засах засгийн газрыг зөвшөөрөхийг шаардана” гэж дурджээ. (1, 42)

Түвшин Нинсяд очоод тус мужийн Ардын засгийн газрын тэргүүлэгчид захидлыг өгөхөд тэр хэлэлцээр хийх тухай дурдсаныг үзээд ХКН-ын үндэстний бодлого болон Өвөр Монгол одоо жинхэнэ өөртөө засахыг хэрэгжүүлж байгаа хэмээн тайлбарлаж, Дэ ванд уулзаж ярилцахыг санал болгосон байна. Түвшин буцаж ирээд өөрийн үзэж мэдсэн тодорхой баримтуудыг дурдан түүнийг элдвээр ятгасан боловч энэ саналыг Дэ ван хүлээж авсангүй. Тэрээр “Үүнээс хойш би яасан ч

хүнээр томилуулсан ноён суухгүй. Олон түмнээр сонгуулсан ноёны тушаалд бол сууна. Би хэзээ аль үед ч гэсэн үндэстнийхээ үйлсийн төлөө тэмцэнэ. Гэвч Бай Юньти мэтийн амьтад ялзран доройтоод эдгээр жилүүдэд Гомиьнданыг дагаж гүйгээд ямар ч юм бүтээж чадсангүй. Улаанхүү харин нэлээд амаргүй хүн. Одоо нэгэнт Монголын улс төрийн байдлыг буй болгож, зүүн баруун Монголыг маш түргэн нэгтгэв. Энэ талаар би түүнийг биширнэ. Харамсалтай нь тэр бол эв хамт намын шугамаар явж байна. Энэ дэлхий дээр үндэстнээ сэргээн мандуулах үйл ажиллагааг өөрийнхөө үүрэг болгосон надаас өөр хэн байх ажээ... Эв хамт намын орон нутгийн өөртөө засах төрийн бодлого нь Гомиьнданы газар орны чанартай өөртөө засах гэдэгтэй ямар ч ялгаа байхгүй. Яалаа ч гэсэн тэд бүгд хятадлууд болохоор монгол хүнд лавтай адил хандах байлгүй” гэсэн байна. (2, 23) Ингээд хүмүүсээ цуглуулан цаашид хэрхэх талаар санал солилцоход олонхи нь баруун тийш явах нь зүйтэй гэсэн бодолтойгоо илэрхийлэв. Дэ ван түрүүчийн захидалд дурсан зүйлд хариу өгөхийг шаардуулахаар Түвшинг хоёрдугаар дивизийн дарга Жарантайн хамт Нинься руу дахин томилон явуулахдаа нөгөө тал нүүр учран ярилцъя гэвэл “машин ирүүлж тосвол би очно” гэсэн байна. Тэр хоёрыг явмагц Дэ ван цэргээ дагуулан Горной голд очиж буудаллав.

Түвшинг Нинся мужид томилон явуулах үедээ Дэ ван Сенид баруун хошууны даргын тушаалд ажиллаж байсан дүү Алтан-Очир руу хүн томилон явуулав. Алтан-Очир 1945 онд Япон бууж өгөх үед Шилийн голд ирсэн Зөвлөлт-Монголын цэрэгтэй харилцаж байсан бөгөөд тэд Дэ ванг манай улсын талд татаж авах ажилд түүнийг ашиглахаар ажилласан байна. Энэ үед Алтан-Очир Алаша хошууны хойт хэсэг буюу Монгол-Хятадын хилийн шугам дээр байж, манайханд мэдээлэл дамжуулж байжээ. Дэ ван 1949 оны 12 дугаар сарын 29-нд Алтан-Очирыг даган Түмэндэлгэр, Цэрэндорж нарын дөрвөн хүний хамт Алаша хошууны Горной голоор хил давж, манай улсад орж ирсэн байна. Ингээд удалгүй Ли Шоусиньд захидалд илгээж “Монголын өөртөө засах засгийн газрын удирдах хүмүүсийнхээ хамт БНМАУ-д ирж их хэрэг зөвлөлдье” гэжээ. Ингээд Ли Шоусинь, Бао Гуйтин, Сүхбаатар, Дүүрэнсан, Номбаатар, Даш нарын зэрэг хорь гаруй хүн манай улсад ирсэн байна. Дэ ван Ли Шоусинь нарыг манай улсад ирсний дараа Монголын өөртөө засах засгийн газрын цэрэг, засгийн удирдах хүмүүс “ард түмний талд орж, найрамдлаар чөлөөлөгдөх” асуудал дээр санал зөрөлдөж, хоёр бүлэг болсон байна. Ингээд Түвшин Алаша хошууны Баян хотод очиж, ХАЧА-ийн Нинся дахь цэргийн тойргийн удирдлагуудтай уулзахад тэд дээд

шатны намын хороо болон Ардын засгийн зааврыг танилцуулж, Өвөр Монголын өөртөө засах засгийн газрын тэргүүлэгч Улаанхүүгээс Дэ ван болон түүний удирдлагад байгаа хүмүүст бичсэн захидлыг гардуулж өгчээ. Мөн нам засгийн уучлах бодлого болон тэдний тухай дурдсан шийдвэрүүдийг тэдэнд гардуулав. (3, 42)

Хятадын коммунист намын дээрх бодлогыг олонхи нь ойлгон хүлээж авсан боловч эсэргүүцэх хүмүүс ч байв. Хорооны дарга Саграажав зуу гаруй хүнээ дагуулан баруун тийш зугтаж, Эзнээ хошууны нутаг дэвсгэрт ороод Ардын чөлөөлөх цэрэгт цохигдсон байна. Мөн нэг хорооны дарга хоёр зуу шахам цэргээ авч, зүүн тийш зугтан Улаанцавын чуулган хүрээд зэвсгээ хураалгажээ. Ингээд үлдсэн мянга хоёр зуу гаруй хүн 1950 оны хоёр гуравдугаар сард “найрамдлаар чөлөөлөгдөж” зэвсгээ хураалгажээ. Эдгээрээс дөрвөн зуу гаруй хүнийг Алаша хошууны хамгаалах цэрэгт үлдээж, мөн дөрвөн зуу орчим хүнд зардал өгч нутагт нь буцаагаад, далаад хүнийг Өвөр Монголд суралцуулахаар авч, зуу гаруйг нь Алаша хошууны Ардын засгийн ордны харьяа газруудад ажиллуулах болж, зуу орчим хүн нь Алаша хошуунд суурьшсан байна.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Дэмчигдонров. “Миний явуулсан баруун Монголын өөртөө засах хөдөлгөөний өнгөрөлт”, Хөххот 1965
2. Дэмчигдонров. “Бээжин дэх гурван жил”, Хөххот 1964
3. Lu Minghui. “Taobuxin fang wen lu”, Huhe haote 1972
4. Лу Минхуй. “Монголын өөртөө засах хөдөлгөөний үүсэл төгсөл” Хөххот 1986
5. Lu Minghui. “De wang qi ren”, Huhe haote 1998
6. Zhaqixiqin. “Wo suo zhidao de De wang he dang shi de Nei menggu”, Beijing 2005
7. Таобухин. “Demuchukedonglupu zi shu”, Huhe haote 1984
8. Түвшин. “Дэмчигдонровын тоочилт” Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо, 1991
9. Хэ Жаолинь. “Баруун Монголын өөртөө засах хөдөлгөөний үүсэл төгслийн товч”, Өвөр Монголын соёл түүхийн лавлалтын материал. Нэгдүгээр эмхэтгэл 1975